

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН					
Хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/					
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй					
Тайлагнах хугацаа		2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдөр			
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар		Компанийн нэр: Худалдаа, хөгжлийн банк ХК (цаашид "Банк" эсхүл “ХХБ” гэх) УБГД: 9007001015 Үнэт цаасны код: MN00TDB05673 Утасны дугаар: 11 328227			
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр		Монголын хөрөнгийн бирж			
Бизнесийн үйл ажиллагааны салбар		Банк, санхүү			
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг		50,600,927			
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр		Бэлтгэсэн: Л.Сайнбаяр - Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх ажлын албаны Гадаад харилцааны мэргэжилтэн Хянасан: Н.Нямсүрэн - ТУЗ-ийн нарийн бичгийн дарга			
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/				
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Хавсралт 1 – Санхүүгийн нэгтгэсэн тайлан			
	Орлогын тайлан				
	Өмчийн өөрчлөлтийн тайлан				
	Мөнгөн гүйлгээний тайлан				
2	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт				
	Хавсралт 2				
3	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт				
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Банк
		1	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	>9%	13.1%
		2	Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	>12%	13.1%
		3	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар)	<+/-15%	-4.4%
		4	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	<+/-15%	-2.9%

3.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Банк																									
		1	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	>25%	41.9%																									
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл																													
	- Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл болон Монголбанкнаас гаргасан Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-уудын санхүүжилтийн Таксономи”-ийг 2026 оноос эхлэн албан журмаар энэхүү шинэ таксономийн дагуу зээлийн багцаа ангилж Монголбанканд мэдээлэл хүргүүлэхээр шийдвэрлэхээр байгаатай холбоотойгоор Худалдаа, хөгжлийн банк нь нийгмийн болон ногоон зээлийн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэхээр судалгаа шинжилгээг хийн ажиллаж байна. Үүний зэрэгцээ цаашид өөрийн тогтвортой санхүүжилтийн чиглэлд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хяналт тайлагнал, ил тод байдал, харилцагчид хүргэх бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах, олон улсын стандартад нийцүүлэхээр ажиллаж байна. - ХХБ нь олон улсын хөрөнгийн зах зээл болон хөгжлийн санхүүжилтийн байгууллагуудтай идэвхитэй хамтран ажилласан хэвээр байна. Тус оны 2-р сард банк өмнө нь гаргасан 200 сая ам.долларын хаалттай бонд дээр нэмэлтээр 100 сая ам.долларыг амжилттай татан төвлөрүүлж, нийт дүнг 300 сая ам.долларт хүргэсэн. Ийнхүү нэмэгдүүлсэн дүн нь уг үнэт цаасыг олон улсын хөрөнгө оруулалтын индексд оруулсан ба илүү олон хөрөнгө оруулагч нар тухайн бондод хөрөнгө оруулах боломжийг нээсэн байна. Гэвч удаагаар АНУ-аас гаралтай татвартай холбоотой урьдчилан тааварлах боломжгүй нөхцөл үүссэн нь хөрөнгө оруулагчдын дунд өндөр өгөөжтэй бондын зах зээлд болгоомжлол үүсгэсэн юм. Үүнийг харгалзан үзэж Банк нь олон улсын хөгжлийн санхүүжилтийн байгууллагуудаас хөнгөлөлттэй эх үүсвэр татах тал дээр илүү анхаарч ажиллаж байна. Энэ хүрээнд, бид АНУ-ын Олон улсын хөгжлийн санхүүжилтийн корпорациас хоёр дахь шатны санхүүжилтийг амжилттай авсан бөгөөд уг эх үүсвэрийг Монгол Улсын жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжихэд ашиглаж байна.																													
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого																													
	Хавсралт 1 – Санхүүгийн нэгтгэсэн тайлан																													
4	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/																													
	Тайлант хугацаанд Банкны ТУЗ-өөс сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосон шийдвэр гараагүй ба 2022 онд ТУЗ-өөс олгосон зөвшөөрлийн үндсэн дээр Монгол Улсын Засгийн газраас 2013 оноос эхлэн хэрэгжүүлж буй ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд иргэдэд олгосон орон сууцны зээлийг багцлан худалдахтай холбоотой 7 гэрээг Монголын ипотекийн корпораци ОССК ХХК-ийн охин компани болох тусгай зориулалтын компаниудтай байгуулсан. Банкны тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу банк нь холбогдох этгээдэд олгосон зээл, гаргасан аккредитив, бусад үүрэг, ажил, үйлчилгээний мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэлдэг. 2025 оны 06-р сарын 30-ны өдөр (сая төгрөгөөр) <table><tr><th colspan="2">Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)</th><th>Активын хэлбэр</th><th>Үлдэгдэл дүн</th><th>Өөрийн хөрөнгөд эзлэх хувь</th></tr><tr><td>1.</td><td colspan="4">Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй)</td></tr><tr><td>1.1.</td><td>Банкны хувьцаа эзэмшигч</td><td>Зээл, Авлага</td><td>-</td><td>0.00%</td></tr><tr><td>1.2.</td><td>Банкны эрх бүхий албан тушаалтан</td><td>Авлага</td><td>419.3</td><td>0.03%</td></tr><tr><td>1.3.</td><td>Банкны бусад холбогдох этгээд</td><td>Авлага</td><td>43,392.7</td><td>2.91%</td></tr></table>					Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)		Активын хэлбэр	Үлдэгдэл дүн	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь	1.	Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй)				1.1.	Банкны хувьцаа эзэмшигч	Зээл, Авлага	-	0.00%	1.2.	Банкны эрх бүхий албан тушаалтан	Авлага	419.3	0.03%	1.3.	Банкны бусад холбогдох этгээд	Авлага	43,392.7	2.91%
Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)		Активын хэлбэр	Үлдэгдэл дүн	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь																										
1.	Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй)																													
1.1.	Банкны хувьцаа эзэмшигч	Зээл, Авлага	-	0.00%																										
1.2.	Банкны эрх бүхий албан тушаалтан	Авлага	419.3	0.03%																										
1.3.	Банкны бусад холбогдох этгээд	Авлага	43,392.7	2.91%																										

	2. Банкны холбогдох нийт этгээд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй) <table border="1"> <tr> <td>2.1.</td> <td>Банкны хувьцаа эзэмшигчид</td> <td>Зээл, Авлага</td> <td>-</td> <td>0.00%</td> </tr> <tr> <td>2.2.</td> <td>Банкны эрх бүхий албан тушаалтнууд</td> <td>Зээл, Авлага</td> <td>2,209.3</td> <td>0.15%</td> </tr> <tr> <td>2.3.</td> <td>Банкны бусад холбогдох этгээд</td> <td>Зээл, Бусад актив</td> <td>101,432.6</td> <td>6.80%</td> </tr> </table> Банк нь Тайлант хугацаанд Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэгт тодорхойлсон их хэмжээний хэлцэл байгуулаагүй байна.	2.1.	Банкны хувьцаа эзэмшигчид	Зээл, Авлага	-	0.00%	2.2.	Банкны эрх бүхий албан тушаалтнууд	Зээл, Авлага	2,209.3	0.15%	2.3.	Банкны бусад холбогдох этгээд	Зээл, Бусад актив	101,432.6	6.80%
2.1.	Банкны хувьцаа эзэмшигчид	Зээл, Авлага	-	0.00%												
2.2.	Банкны эрх бүхий албан тушаалтнууд	Зээл, Авлага	2,209.3	0.15%												
2.3.	Банкны бусад холбогдох этгээд	Зээл, Бусад актив	101,432.6	6.80%												
5	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл															
	Худалдаа, хөгжлийн банк ("ХХБ") нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг дунд хугацааны Бизнес төлөвлөгөөний зорилтоо хэрэгжүүлэх ажлын хүрээнд банкны үндсэн бүтээгдэхүүн болох зээл олголтод зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд "Ногоон банк" болох урт хугацааны тэргүүлэх дэд стратеги чиглэлийн хүрээнд ХХБ-ны "Тогтвортой санхүүжилтийн хүрээ" баримт бичигт тусгагдсан ногоон болон нийгмийн зээлийн ангиллуудад уялдуулан санхүүжилт олгосон. Анхдагч зах зээлийн арилжаанд нийт 2'528 хөрөнгө оруулагчдаас 105.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий захиалга хүлээн авч, татан төвлөрүүлэх зорилтот дүн болох 83.5 тэрбум төгрөгийн захиалга 126.4% гүйцэтгэлтэйгээр хаагдсан. Банк нь активын зохистой бүтцийг бий болгох, иргэд болон жижиг, дунд бизнесийн зах зээлд тэлэлт хийх стратеги төлөвлөгөөний дагуу татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтыг бизнесийн сегментүүдийн ногоон болон нийгмийн зээлийн санхүүжилтэд төлөвлөсний дагуу 2024 оны 3-р улиралд амжилттайгаар бүрэн гүйцэтгэж дуусгасан байна.															
6	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл															
	Хавсралт 3															
7	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл															
	Хавсралт 3															
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо: Овог, нэр: О.ОРХОН Албан тушаал: "ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК" ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ✓ Гарын үсэг: (Тамга/тэмдэг)																
Мэдээлэл баталсан хураархсан этгээдийн гарын үсэг, огноо: Овог, нэр: Н.НЯМСҮРЭН Албан тушаал: ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Гарын үсэг: (Тамга/тэмдэг)																

Байгууллагын нэр: Худалдаа хөгжлийн банк

Регистр: 2635534

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,572,256,753	2,591,760,711
1.1.1	Бэлэн мөнгө	64,286,886	91,525,833
1.1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө	1,669,655,007	1,147,779,682
1.1.3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	1,837,294,011	1,352,250,290
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,020,849	204,906
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	2,756,341,403	2,665,051,700
1.2.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгө	2,756,935,248	2,665,645,545
1.2.2	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	-	-
1.2.3	Бусад хөрөнгө	-	-
1.2.4	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	-	-
1.2.5	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сан	(593,845)	(593,845)
1.3	Хөрөнгө оруулалт	1,066,849,253	1,254,536,432
1.3.1	Арилжааны үнэт цаас	-	-
1.3.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	1,040,448,518	1,212,969,523
1.3.3	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	-	2,521,787
1.3.4	Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас	-	-
1.3.5	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	164,244	164,244
1.3.6	Барьцаанд байгаа үнэт цаас	-	-
1.3.7	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	26,236,491	38,880,878
1.3.8	Үнэт цаасны эрсдэлийн сан	-	-
1.4	Зээл (цэвэр дүнгээр)	6,179,569,553	7,690,783,856
1.4.1	Хэвийн зээл	5,680,941,171	7,178,895,800
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	409,081,945	455,896,834
1.4.3	Хэвийн бус зээл	90,870,751	51,533,636
1.4.4	Эргэлзээтэй зээл	6,461,441	22,329,277
1.4.5	Муу зээл	162,916,235	218,360,340
1.4.6	Зээлийн хойшлогдсон төлбөр	(22,505,082)	(22,505,082)
1.4.7	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	160,017,967	141,500,971
1.4.8	Зээлийн эрсдэлийн сан	(308,214,875)	(355,227,920)
1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	88,784,131	83,942,942
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	113,516,923	153,306,075
1.6.1	Бусад санхүүгийн хөрөнгө	101,901,106	140,572,250
1.6.2	Банк, салбар хоорондын тооцоо	9,475,546	10,744,159
1.6.3	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	-	-
1.6.4	Бусад	2,140,271	1,989,665
1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	441,793,725	293,158,700
1.7.1	Бусад тооцоо	36,142,983	59,607,504
1.7.2	Бараа материал, үнэ бүхий зүйл	14,513,521	6,741,134
1.7.3	Үнэт металл (цэвэр дүнгээр)	163,162	9,640,362
1.7.4	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	389,450,166	215,612,443
1.7.5	Татварын авлага	1,334,843	1,334,843
1.7.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.7.7	Бусад	189,050	222,414
1.8	Үндсэн хөрөнгө	557,507,597	584,699,099
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	80,749,541	59,813,135
1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	95,381,015	132,611,744
1.11	Биет бус хөрөнгө	47,618,788	48,264,304
1.12	Нийт хөрөнгийн дүн	15,000,368,683	15,557,928,698
2	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1	Харилцах	3,589,983,877	2,901,145,520
2.1.1	Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	3,589,983,300	2,901,144,935
2.1.2	Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	576	585
2.2	Хадгаламж	6,065,437,491	6,849,491,593
2.2.1	Хугацаагүй хадгаламж	646,864,177	771,108,677
2.2.2	Хугацаатай хадгаламж	5,262,513,396	5,865,571,538
2.2.3	Бусад төрлийн хадгаламж	1,155,000	1,557,005
2.2.4	Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	154,904,918	211,254,373
2.3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	2,605,363,346	2,854,640,835

2.3.1	Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж	976,901,747	395,238,238
2.3.2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (хугацаа хэтэрсэн зээлийн дүнг оруулсан)	1,621,308,559	2,447,916,569
2.3.3	Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	(5,577,059)	(5,686,572)
2.3.4	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	12,730,100	17,172,599
2.4	Бусад эх үүсвэр	816,269,796	1,191,395,309
2.4.1	Банкнаас гаргасан өрийн бичиг	-	-
2.4.2	Банкнаас гаргасан үнэт цаас	666,848,059	1,070,092,035
2.4.3	Төслийн зээлийн санхүүжилт	39,292,368	36,889,390
2.4.4	Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (репо)	21,990,771	-
2.4.5	Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр	-	-
2.4.6	Бусад	80,680,022	79,718,966
2.4.7	Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	-	-
2.4.8	Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	7,458,576	4,694,918
2.5	Дериватив санхүүгийн өр төлбөр	70,630,118	69,336,921
2.6	Бусад санхүүгийн өр төлбөр	139,481,989	165,478,844
2.7	Бусад санхүүгийн бус өр төлбөр	97,216,480	33,754,724
2.8	Хоёрдогч өглөг	-	-
2.9	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-
2.10	Нийт өр төлбөрийн дүн	13,384,383,096	14,065,243,747
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	-	-
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	340,852,904	340,852,904
3.1.1	Давуу эрхийн хувьцаа	-	-
3.1.2	Энгийн хувьцаа	340,852,904	340,852,904
3.2	Нэмж төлөгдсөн капитал	64,069,779	64,069,779
3.3	Халаасны хувьцаа	-	-
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	143,364,654	139,031,790
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	892,938,857	903,582,289
3.6	Бусад өөрийн хөрөнгө	174,759,391	45,148,189
3.6.1	Хувьцааны опцион	-	-
3.6.2	Нөөцийн сан	494,516	494,516
3.6.3	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
3.6.4	Эрсдэлийн сангийн нөөц	129,398,712	-
3.6.5	Нийгмийн хөгжлийн сан	-	-
3.6.6	Хувьцаанд хөрвөх үнэт цаас (өөрийн хөрөнгө)	-	-
3.6.7	Хувьцаанд хөрвөх эх үүсвэр (өөрийн хөрөнгө)	-	-
3.6.8	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан	-	-
3.6.9	Хейджийн хэрэгслийн дахин үнэлгээний сан	-	-
3.6.10	Бусад	44,866,163	44,653,673
3.7	Өөрийн хөрөнгийн дүн	1,615,985,586	1,492,684,951
4	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	15,000,368,683	15,557,928,698

0.00

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

СУХГ-ЫН ЗАХИРАЛ

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



О.ОРХОН

Д.ЭНХТУЯА

М.МӨНХБАЯР

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

		/Мянган төгрөг/	
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Хүүгийн орлого	1,085,996,675	660,462,784
1.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгийн	37,798,844	8,496,640
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	48,189,863	19,551,191
1.3	Үнэт цаасны	234,071,425	129,326,147
1.4	Зээлийн	765,936,544	485,196,545
1.5	Бусад хүүгийн орлого	0	17,892,262
2	Хүүгийн зардал	602,479,107	476,266,561
2.1	Харилцахад төлсөн хүү	58,066,542	23,335,074
2.2	Хадгаламжинд төлсөн хүү	469,211,146	327,194,243
2.3	Зээлийн хүүгийн зардал	64,570,979	31,708,769
2.4	Үнэт цаасны хүүгийн зардал	8,827,830	93,821,519
2.5	Бусад хүүгийн зардал	1,802,610	206,956
3	ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО(1-2)	483,517,568	184,196,223
4	Эрсдэлийн сангийн зардал	0	38,661,062
4.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	0	0
4.2	Үнэт цаасны	0	0
4.3	Зээлийн	0	38,661,062
5	Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]	483,517,568	145,535,161
6	Бусад орлого	216,911,342	194,865,890
6.1	Хүүгийн бус орлого	215,435,121	192,643,180
6.1.1	Арилжааны орлого	48,621,463	25,625,487
6.1.2	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	18,315,365	36,175,264
6.1.3	Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	116,961,225	78,184,506
6.1.4	Бусад хүүгийн бус орлого	31,537,068	52,657,922
6.2	Бусад орлого, олз	1,476,221	2,222,711
7	Бусад зардал	312,223,045	228,686,319
7.1	Хүүгийн бус зардал	297,878,626	227,595,111
7.1.1	Бусад эрсдэлийн сангийн зардал	28,910,036	34,537,625
7.1.2	Арилжааны зардал	4,524,781	0
7.1.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	1,186,163	41,213,645
7.1.4	Хураамж, шимтгэлийн зардал	48,601,606	32,335,888
7.1.5	Үйл ажиллагааны бусад зардал	214,656,039	119,507,952
7.2	Бусад зардал, гарз	14,344,419	1,091,208
8	Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)	388,205,865	111,714,733
9	Орлогын татварын зардал	89,570,244	140,853
10	Татварын дараах ашиг, алдагдал (8-9)	298,635,621	111,573,880
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	0	0
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)	298,635,621	111,573,880
13	Бусад дэлгэрэнгүй орлого	9,451,129	-4,545,354
13.1	Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны өсөлт, бууралт	0	-4,332,864
13.2	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний өсөлт, бууралт	9,451,129	-212,490
13.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сангийн өсөлт, бууралт	0	0
13.4	Эрсдэлийн сангийн нөөцийн өсөлт, бууралт	0	0
13.5	Бусад	0	0
14	Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (12+13)	308,086,749	107,028,526

№	Тэнцлийн гадуурх данс	/Мянган төгрөг/
1	Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг (цэвэр дүнгээр)	1,355,961,298

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



О.ОРХОН

СУХГ-ЫН ЗАХИРАЛ

Д.ЭНХТУЯА

САНХҮҮГИЙН ШИНЖЭЭЧ

Э.БАДРАЛ

Байгууллагын нэр: Худалдаа хөгжлийн банк

Регистр: 2635534

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	***	***
1.1	Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	388,205,865	111,714,733
1.2	Орлого, зардлын тохируулга	(654,728,808)	(157,189,348)
1.2.1	Эрсдэлийн сангийн зардал (+)	(183,563,186)	19,636,376
1.2.2	Элэгдэл, хорогдлын зардал (+)	12,351,946	7,370,500
1.2.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (-), зардал (+) (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад)	-	-
1.2.4	Хуримтлуулсан хүүгийн орлого (-)	(1,085,996,675)	(660,462,784)
1.2.5	Хуримтлуулсан хүүгийн зардал (+)	602,479,107	476,266,561
1.2.6	Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+)	-	-
1.2.7	Бусад олз (-), гарз (+)	-	-
1.3	Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга	(908,130,092)	(1,237,778,772)
1.3.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(1,706,939,607)	91,454,281
1.3.2	Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+)	-	-
1.3.3	Зээлийн өсөлт (-), бууралт (+)	(1,244,436,501)	(1,624,056,761)
1.3.4	Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	171,053,772	(23,368,454)
1.3.5	Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(213,270,904)	59,158,821
1.3.6	Харилцах, хадгаламжийн өсөлт (+), бууралт (-)	1,107,925,062	38,866,283
1.3.7	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-)	1,037,924,769	193,531,719
1.3.8	Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	(113,605,252)	81,926,002
1.3.9	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	53,218,570	(55,290,662)
1.4	Бусад тохируулга	437,755,909	213,867,985
1.4.1	Авсан хүү (+)	1,116,782,467	634,054,399
1.4.2	Төлсөн хүү (-)	(589,456,313)	(420,045,561)
1.4.3	Орлогын татварын төлөлт (-)	(89,570,244)	(140,853)
1.4.4	Эрсдэлийн сангаас хаасан зээл, авлага (-)	-	-
1.4.5		-	-
1.5	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(736,897,125)	(1,069,385,401)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	***	***
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,637,282,315	1,452,866,880
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	96,240,769	12,195,535
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	3,124,412	473,792
2.1.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсны орлого	2,478,546	-
2.1.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт борлуулсны орлого	5,031,979	5,031,979
2.1.5	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.6	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.7	Борлуулахад бэлэн үнэт цаас борлуулсны орлого	884,528,264	1,300,057,921
2.1.8	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас борлуулсны орлого	423,918,804	142,559
2.1.9	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.10	Бусад мөнгөн орлого	221,959,542	134,965,094
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(1,763,027,858)	(1,479,060,363)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	154,293,824	26,530,376
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	23,453,186	1,810,167
2.2.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	23,989,866	3,053,461
2.2.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	4,271,538	-
2.2.5	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.6	Борлуулахад бэлэн үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	1,402,764,109	1,302,758,731
2.2.7	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	16,409,182	2,664,346
2.2.8	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.9	Бусад мөнгөн зарлага	137,846,152	142,243,281

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(125,745,543)	(26,193,483)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	***	***
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,973,424,391	2,881,368,490
3.1.1	Бусад эх үүсвэр татаж хүлээн авсан	5,452,632,480	2,012,266,195
3.1.2	Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	-	-
3.1.3	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.4	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.5	Бусад	520,791,911	869,102,294
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(5,405,692,459)	(2,766,285,648)
3.2.1	Бусад эх үүсвэрт төлсөн	4,865,482,618	1,801,067,633
3.2.2	Хоёрдогч өглөгт төлсөн	-	-
3.2.3	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.4	Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	-	-
3.2.5	Төлсөн ногдол ашиг	104,541,515	101,201,854
3.2.6	Бусад	435,668,326	864,016,161
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	567,731,932	115,082,842
4	Валютын ханшийн зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(294,910,736)	(980,496,042)
6	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,867,167,489	3,572,256,753
7	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,572,256,753	2,591,760,711

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

СУХГ-ЫН ЗАХИРАЛ

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



О.ОРХОН

Д.ЭНХТУЯА

М.МӨНХБАЯР

Байгууллагын нэр: Худалдаа хөгжлийн банк
Регистр: 2635534
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

№	Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Халаасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт Дүн
8	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	340,852,904	64,069,779	0	143,479,413	170,688,278	689,288,519	1,408,378,894
1	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0	0	0	0
2	Залруулсан үлдэгдэл	340,852,904	64,069,779	0	143,479,413	170,688,278	689,288,519	1,408,378,894
3	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	0	0	0	0	0	298,635,621	298,635,621
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	9,451,129	0	9,451,129
5	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0	-5,380,015	7,375,972	1,995,956
6	Хуваарилсан ногдол ашиг	0	0	0	0	0	-104,541,515	-104,541,515
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	-114,759	0	2,180,261	2,065,502
8	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	340,852,904	64,069,779	0	143,364,654	174,759,391	892,938,857	1,615,985,586
1	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0	0	0	0
2	Залруулсан үлдэгдэл	340,852,904	64,069,779	0	143,364,654	174,759,391	892,938,857	1,615,985,586
3	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	0	0	0	0	0	111,573,880	111,573,880
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	-4,061,458	-212,490	0	-4,273,948
5	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0	-129,398,712	0	-129,398,712
6	Хуваарилсан ногдол ашиг	0	0	0	0	0	-101,201,854	-101,201,854
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	-271,406	0	271,406	0
8	2025 оны 6-р сарын 30-ны үлдэгдэл	340,852,904	64,069,779	0	139,031,790	45,148,189	903,582,289	1,492,684,951

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

СУХГ-ЫН ЗАХИРАЛ

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



О.ОРХОН

Д.ЭНХТУЯА

М.МӨНХБАЯР

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ
АУДИТЫН ХОРООНЫ ДҮГНЭЛТ

2025 оны 07 дугаар сарын 08

Улаанбаатар хот

Аудитын хорооны хурлаар банкны санхүүгийн тайлангийн хагас жилийн үзүүлэлтүүдтэй танилцлаа. Худалдаа хөгжлийн банк нь 2025 оны эхний хагас жилд 15.5 их наяд төгрөгийн активтай, 111.7 тэрбум төгрөгийн татварын өмнөх ашигтай, Монголбанкнаас тогтоосон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна. Банк нь 2025 оны эхний хагасд ТУЗ-өөс өгсөн актив, пассивын төсөв, төлөвлөгөөг биелүүлсэн нь сайн үр дүн гэж үзлээ. Харин үйл ажиллагааны орлогыг төлөвлөсөн хэмжээнд хүргэж чадаагүй, өмнөх оны мөн үетэй харьцуулахад татварын өмнөх ашиг буурсан, зарим гол пассивын үзүүлэлтүүд төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байгаад анхаарч шалтгааныг тодруулах, сүүлийн хагас жилд тодорхой төлөвлөгөө гаргаж ажиллахыг зөвлөж байна.

Аудитын хорооноос 2025 оны хагас жилийн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлантай танилцаж, компанийн санхүүгийн тайлангийн тоон үлдэгдлүүд нь Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бодитоор илэрхийлэгдсэн гэж дүгнэлээ.

АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА



Ж.ДЭЛГЭРСАЙХАН

Компанийн засаглал

Худалдаа, хөгжлийн банк ХК (цаашид “ХХБ” эсхүл “Банк” гэх) нь Компанийн засаглалын чиглэлээрх бодлого, дүрэм, журам, заавруудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон засаглалын үнэлгээг оновчтой, бодитоор гаргаж, хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд үнэ цэнэ бүтээхэд дэмжлэг үзүүлэх, дотоодын төдийгүй олон улсын сайн туршлагыг нутагшуулан ТУЗ болон банкны бүхий л нэгжид хүрч, банкны стратеги төлөвлөгөө, байгууллагын бүтэц, бодлогыг тодорхойлон, оролцогч талуудын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдол өгч ажилладаг.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ



Хувьцаа эзэмшигчдийг эрх тэгш байдлаар хангах үүднээс Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөрийг Төлөөлөн удирдах зөвлөлөөр баталсан төдийгүй ХХБ-ны дүрэмд хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийг тусгасан нь эзэмшлийн хэмжээнээс үл хамааран эрх тэгш, ил тод нээлттэй мэдээллийг авах нөхцөлийг бий болгон ажиллаж байна.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох зохицуулагч байгууллагуудаас баталсан журмуудад бүх хувьцаа эзэмшигчдийг мэдээллийг ижил хэмжээнд хүлээн авах, санал өгөх эрхийг хамгаалсан зохицуулалтууд нарийвчлан тусгасан байдаг. Ийнхүү хувьцаа эзэмшигч бүрт эрх тэгш үйлчлэх, харилцах зарчмуудыг тодорхойлохоос гадна хувьцаа эзэмшигчидтэй тухайлан харилцах Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх ажлын албыг бий болгосон нь байгууллагын хариуцлага, засаглалыг дэмжиж үр ашигтай байдлаар холбогдох сувгаар дамжуулан санал хүсэлт, харилцан мэдээлэл солилцох итгэлцэл болон оролцоог нэмэгдүүлэн, нийтлэг ашгийг хамгаалж, тогтвортой нээлттэй харилцааг өргөжүүлэн ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)

ХХБ нь ТУЗ-ийг олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, ашиг сонирхлын зөрчил, хараат бус байдал, хүйсийн тэнцвэр зэргийг зохистойгоор хангасан гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр бүтээлч, үр дүнтэй бүтэцтэй байлгахыг зорьдог ба Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгон томилно.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Банкны эрх барих дээд нэгжийн хувьд жендерийн эрх тэгш байдлыг эрхэмлэн үзэж, шийдвэр гаргах түвшинд оролцооны эрх тэгш харьцааг хангахыг зорьж ажилладаг төдийгүй, ХХБ-ны дүрэмд ТУЗ нь 9 гишүүнтэй, үүний 1/3 хараат бус гишүүнт байхаар Компанийн тухай хууль, Банкны тухай хуулийг мөрдлөг болгон баталсан нь сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх, ТУЗ-ийн шийдвэр гаргалтад хараат бус гишүүдийг оролцоо, бие даасан байдлыг хангахад гол чиглүүлэгч болдог.

ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа сонгогдсоноор эхэлж, түүнийг ТУЗ-ийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлснөөр дуусгавар болно. Банкны ТУЗ-ийн гишүүд нь ердийн болон хараат бус гишүүнд тавигддаг тусгайлсан шаардлагуудыг хангасан нь олон жилийн туршлагатай, банкныг удирдан

чиглүүлэхэд мэдлэг ур, чадвар, боловсрол, ёс зүйн болон бизнесийн нэр хүндийн хувьд нийцсэн гэдгийг харуулж байна.

ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга: <https://www.tdbm.mn/mn/investment/toloolon-udirdah-zovlol>

ТУЗ-ийн дэргэдэх хороод

ТУЗ нь дэргэдээ Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо, Аудитын хороо болон Эрсдэлийн удирдлагын хороо гэсэн байнгын хороодтой ба эдгээр хороод нь хараат бус гишүүдээр даргалуулж, банкны удирдлага болон ажилтнаас бүрэлдэхүүнд байдаггүй нь ТУЗ-ийн шийдвэр гаргалтад бие даасан байдлыг бий болгох зарчмыг хангаж байгаа төдийгүй хороод үйл ажиллагаагаа зохион байгуулах, зохицуулах журам заавартай ба ТУЗ болон шаардлагатай тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнахаар заасан байна. Мөн ТУЗ-ийн дэргэд банкны үйл ажиллагаа, тогтвортой санхүүжилт, байгаль орчин, нийгэм засаглалын чиглэлээр дэмжлэг, зөвлөмж өгөх чиг үүрэг бүхий Тогтвортой хөгжлийн хороог байгуулан ажиллаж байна.

Хороодын танилцуулга: <https://www.tdbm.mn/mn/investment/toloolon-udirdah-zovloliin-dergedeh-horood>

Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо (ЦУНДХ)

ЦУНДХ нь ХХБ-ны ТУЗ-ийн хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, ашигтайгаар хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх эрх, үүрэг бүхий 3 гишүүний бүрэлдэхүүнтэй, 2/3 буюу 2 гишүүн нь хараат бус гишүүн байна. Тус хороо нь ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүнд эргэн хяналт хийх, гишүүдийг сонгон шалгаруулах, үнэлэх, Гүйцэтгэх удирдлага болон удирдлагын түвшний захирлуудыг нэр дэвшүүлэх, ТУЗ-ийн үйл ажиллагааг дүгнэж тайлагнах, тэдгээрийн цалин хөлс урамшууллын хэмжээ, бодлогыг тодорхойлох, банкны бүтэц, зохион байгуулалт, засаглалыг хөгжүүлэх чиглэл өгөх зэргээр эрх үүрэгтэй хороо болно.

Эрсдэлийн удирдлагын хороо (ЭУХ)

Тус хороо нь 3 гишүүнтэй бөгөөд Банкны тухай хуулийн дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүнээр даргалуулсан, ТУЗ-ийн үйл ажиллагаанд Монгол улсын хууль журам, зохицуулагч болон олон улсын байгууллагууд, Базелийн хорооноос тогтоосон зөвлөмж, стандарт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо, бодлого зэргийн хэрэгжилтийг хянах, чиглэл өгөхөд дэмжлэг үзүүлэх чиглэлийн хороо юм. Үйл ажиллагааны өргөн цар хүрээг хамарч хараат бус байдлаар эрсдэлээс хамгаалах, зах зээл, үйл ажиллагааны эрсдэл болон комплайнсын хэрэгжилтэнд баталгаажуулалт хийж, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж өгч ажилладаг.

Аудитын хороо

Аудитын хороо нь Банкны засаглал, хууль тогтоомжийн хэрэгжилт, ёс зүйн хэм хэмжээ, санхүүгийн тайлагналт, дотоод хяналтын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудитын үйл ажиллагаанд системтэйгээр дүгнэлт өгөх, банкны хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон бусад оролцогч талуудад үнэн зөв бодит мэдээллийг хүргэх замаар байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүх түвшинд сайн засаглалын тогтолцоог бэхжүүлэх зорилготой.

Дотоод аудитын хараат бус, бие даасан байдлыг хангах үүднээс Дотоод аудитын газар нь ТУЗ-ийн шууд удирдлага дор ажилладаг ба ТУЗ-ийн дэргэдэх хараат бус гишүүнээр даргалуулсан Аудитын хороонд ажлаа тайлагнадаг нь хяналтын нэгжийн үүргийг хараат бус, бие даасан байдлаар хэрэгжүүлэх боломжийг хангадаг.

Тогтвортой хөгжлийн хороо:

Тогтвортой хөгжлийн бодлогоор банкны засаглал, стратеги, зорилго, зорилтыг тодорхойлох, дотоод, гадаадын сайн туршлагыг банкны төдийгүй оролцогч талуудын үйл ажиллагаанд нутагшуулах, ногоон болон тогтвортой бизнесийн зарчмууд, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор байгуулагдаж олон улсын туршлагатай зөвлөх, мэргэшсэн, туршлагатай гишүүдтэй, банкныхаа үйл ажиллагааны бүхий л түвшинд сайн засаглалын удирдлага, бодлогыг хэрэгжүүлэх замаар ажиллахаар байгуулагдсан хороо юм.

Гүйцэтгэх удирдлага

ХХБ ХК-ийн дүрмэнд Банкны гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-өөс томилогдсон Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэхээр заасан бөгөөд ноён О.Орхон 2016 оны 1 сараас тус банкны Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. ТУЗ-ийн гишүүдээс гадна дараах албан тушаалтнуудыг Банкны эрх бүхий албан тушаалтан байхаар дүрмэнд заасан ба Дижитал шилжилт хариуцсан Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч шинээр томилогдсон байна

№	Албан тушаал	Нэр	Эзэмшиж буй хувьцааны тоо, ширхэг
1	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Н.Нямсүрэн	-
2	Гүйцэтгэх захирал	О.Орхон	290
2	Ерөнхийлөгч		
3	Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч	А.Энхмэнд	-
4	Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч	О.Банзрагч	-
5	Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч	Дэ Юүн Мартэйн Кристофэл	-
6	Дотоод аудитын газрын захирал	Ч.Лхагвасүрэн	-
7	Санхүүгийн, удирдлага, хяналтын газрын захирал	Д.Энхтуяа	-

Ил тод байдал

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр амжилттай зохион байгуулж, дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлүүлсэн:
 - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт;
 - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
 - Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах.
- Тайлант хугацаанд дараах тайлангуудыг гаргасан. Үүнд:
 - Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журмын дагуу зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн тайлан;
 - Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодекс заасны дагуу ХХБ-ны 2024 оны Засаглалын хэрэгжилтийн тайлан;
 - Байгаль орчин, нийгэм засаглалын тайлан;
 - 2024 оны үйл ажиллагааны тайлан;

- 2024 оны санхүүгийн аудитлагдсан тайлан;
- 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан;
- 2024 оны ТУЗ-ийн дэргэдэх хороодуудын ажлын тайлан;
- ХХБ ХК-аас 2024 онд бусад оролцогч талуудтай хамтран ажилласан талаар тайлан;
- ТУЗ-ийн хараат бус гишүүдийн улирал тутмын ажлын тайлан;
- ТУЗ, түүний дэргэдэх хороод болон ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээ;
- Банкны 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт.

- Тайлант хугацаанд ТУЗ 7 удаагийн хурлаар нийт 19 тогтоол гаргасан.

Нээлттэй хувьцаат компанийн хувьд Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн холбогдох заавар журмуудын дагуу хугацаат тайлан мэдээг тухай бүр хүргэж, хувьцааны үнэ ханшид нөлөөлөх, удирдлагын өөрчлөлт, сонирхлын зөрчилтэй хэлцэл зэрэг мэдээллүүдийн өөрийн албан ёсны болон МХБ-ийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлэн ажиллаж байна.

Ногдол ашгийн мэдээлэл

ТУЗ-ийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 19 тоот тогтоолоор Банкны 2024 оны цэвэр ашгаас нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж энгийн хувьцаанд 2,000.00 (хоёр мянга) төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэж, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2025 оны 4 дүгээр сарын 7-ны өдрөөр тогтоосон бөгөөд Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг татвар суутгасны дараах дүнгээр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан тараав.